ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр                                                                 Улаанбаатар хот

| № | ЗОРИЛТ | АРГА ХЭМЖЭЭ | ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ | ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ, ХЭРЭГЖИЛТ | ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; | -Баримтжуулсан байх<br>-Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо)<br>-Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх. | Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн хэвлэмэл болон хөдөлгөөнт төхөөрөмж дээр ажиллах бүх мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд түгээж, цахим хуудасны нүүр хэсэгт байгууллагын холбоос, авлигаас урьдчилан сэргийлэх санал хүсэлтийн форм, богино хэмжээний шторкуудыг байршуулсан байна.<br><br>Байгууллагын цахим хуудасны www.uds.ub.gov.mn Хууль эрх зүйн буланд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомж, "ТАНЫ ЭРХ, ТАНЫ ОРОЛЦОО. АВЛИГАД ҮГҮЙ ГЭЖ ХЭЛЬЕ" зөвлөмжийг байршуулж, албан өрөөнүүдэд "АВЛИГЫН ЭСРЭГ НЭГДЬЕ" 110 зурагт хуудсуудыг байршуулж, зөвлөмжийг мөрдөж ажиллаж байна.<br><br>Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системийн холбоос, болон "Авлигын эсрэг хамтдаа" таныг сонсож байна буланг тогтмол ажиллуулж байна.<br><br>Авлигатай тэмцэх газраас гаргасан Соён гэгээрүүлэх аяны хүрээнд "Авлигыг мэдээл 110" - "Зөв зөвд Шударга зөв наалтыг байгууллагын 11 албан тасалгааны өрөөний үүдэнд байршуулсан. | 100 |
| | | 1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт | -2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг | Байгууллагын Ёс зүйн дэд хорооноос байгууллагын ёс зүй, үнэт зүйл, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, авлига, ашиг сонирхлоос ангид байх сэдвийн хүрээнд ерөнхий мэдлэг шалгах 5 асуулт бүхий тестийг 69 албан хаагчаас авсан.<br>Судалгаанд хамрагдсан 69 албан хаагчийн 57% нь зөв хариулсан ба цаашид албан хаагчдын дунд дараах 2 төрлөөр сургалт зохион | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | тохируулан зохион байгуулах; | зохион байгуулсан байх;<br>-Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх. | байгуулж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, соён гэгээрүүлэх шаардлагатай дүгнэлтийг газрын даргад танилцуулсан. Үүнд:<br>1. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль<br>2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, журам, албан хувцаслалт, харилцаа, хандлагын талаар ёс зүйн сургалтыг зохион байгуулах.<br><br>Газрын даргад танилцуулсаны дагуу Авлигатай тэмцэх газрын www.iaac.mn/training цахим хуудсаар 4 чиглэлээр сургалт авах хүсэлтийг хүргүүлсэн.<br><br>Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн Комиссар, мэргэжилтэн С.Баярцэцэг “Төрийн албан хаагчдыг авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх” сэдэвт сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр хийж, сургалтад байгууллагын албан хаагчдын 90% хамрагдсан.<br><br>Байгууллагын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан арга хэмжээний хүрээнд байгууллагын нийт албан хаагчдын дунд Үндсэн хуулийн түүхэн ач холбогдол, Үндсэн хуульт төрийн байгуулал, хууль ёсоо эрхэмлэн дээдлэх үзэл санааг таниулах, үндэсний үнэт зүйлдээ хандах мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах, ёс зүйн манлайллыг төлөвшүүлж, итгэл төрүүлэх төрийн үйлчилгээг бий болгох соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулахаар Газрын даргын 2025 оны 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/63 дугаар тушаалаар батлуулж, 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан. Сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 1,200,000 төгрөг зарцуулав. https://www.facebook.com/uda.ub.gov<br><br>Авлигын эсрэг олон улсын өдөр буюу 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | зам" сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд Хот байгуулалт, хотын стандартын газрын дарга оролцов.<br><br>Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын талаарх онолын болон практик судалгаа, дүн шинжилгээг хөгжүүлэх, үр дүнг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн "Шударга ёс" онол арга зүйн сэтгүүлийг түгээн сурталчилан ажиллав.<br>www.facebook.com/groups/1873355006275950/posts/3550320638579370<br>https://erp.ulaanbaatar.mn/#/home/64ba2f70ffc2e4165ff9be42 | |
| | | 1.3.Авлигын эсрэг үйл ажиллагаа мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах; | -Мэдээллийг сар бүр шинэчлэх;<br>-Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх | Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбараар байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг сурталчлан холбогдох мэдээллийг байршуулав. Үүнд:<br>Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ сар бүр (сарын мэдээ)<br>Албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ сар бүр (эхний 11 сарын мэдээ)<br>"Ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх аян"-ны удирдамж Авлигатай тэмцэх газраас санаачлан гаргасан "ИРГЭН ТАНД" хуудасны мэдээлэл,<br>https://www.facebook.com/groups/1873355006275950<br>Авлигатай тэмцэх газрын Facebook хуудасны "ЭБАТ Мэдээлэл" хэсгээс цаг үеийн болон сургалт, зохион байгуулалтын бусад арга хэмжээний мэдээллийг тухай бүр авч ажиллав. | 100 |
| | | 1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгаа хийж | -2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх;<br>-Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны | Байгууллагын дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөлөөс "АВЛИГАГҮЙ ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ – АВЛИГА ГАРЦ БИШ" зурагт хуудас гарган Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын ERP нэгдсэн системээр болон байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудас зэрэгт байршуулан залуучуудын санал санаачилгыг түгээж, нийт албан хаагчдад уриалан ажиллав. https://uds.ub.gov.mn/avilaga.php<br><br>Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт "Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй" гэж заасны дагуу албан хаагчид хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөв, хариуцлагатай мэдүүлэхийг анхаарч, Авлигатай тэмцэх газраас гаргасан ХАСХОМ гаргах зөвлөмж, зааварчилгаа, мөн Мэдүүлэг гаргагч нарт зориулсан зааварчилгааг тухай бүр нийт албан хаагчдад хүргэж ажиллав. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | олон нийтэд хүргэсэн байх. | самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх. | https://www.youtube.com/watch?v=tGN5w6c1S6E https://www.youtube.com/watch?v=n2ppLUgFY6E https://www.youtube.com/watch?v=eU6imNh7oWw https://www.youtube.com/watch?v=OxtvXmRDpOk<br><br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системд байршуулж, сурталчилсан хэвлэмэл хуудас, уриалгыг дэмжин ажиллав. Үүнд "АВЛИГААС ТАТГАЛЗАХ БОЛОМЖ БИДЭНД БИЙ", "ЭРҮҮЛ НИЙГЭМД ИРГЭН ТАНЫ, АЖИЛТАН МИНИЙ ОРОЛЦОО ЧУХАЛ" 110 утас руу үнэгүй залгах боломжтой", "АВЛИГА ӨГӨХӨӨС, АВАХААС ТАТГАЛЗЪЯ".<br><br>Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд зааснаар татвар ногдуулах орлого олсон иргэн бүр 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор Татварын албанд тайлангаа ирүүлэх үүрэгтэй. Төрийн албан хаагч Таны татварын тайлангийн мэдээлэл ХАСХОМ дээрх өөрийн орлогын мэдүүлэгтэй тохирч байх талаар www.etax.mta.mn цахимаар тайлагнаж анхаарч ажиллах талаар мэдээлэл хүргүүлсэн.<br><br>Хот байгуулалт, хотын стандартын газрын Ес зүйн дэд хорооноос уриалга зөвлөмж гарган нийт албан хаагчдад танилцуулж, газрын фэйсбүүк цахим хуудаст байршуулав. https://www.facebook.com/groups/1873355006275950 | |
| 2 | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамруулах | 2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх; | -Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Албан хаагчдад зориулсан ажлын байран дахь сургалтын хөтөлбөрийг 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Газрын даргаар батлуулав. Шинээр томилогдсон албан хаагчдад хөтөлбөрийн дагуу 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр 8 албан хаагчдад сургалт зохион байгуулав.<br><br>Шинээр томилогдсон 15 албан хаагчдад Төрийн албаны хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | зүйн хэм хэмжээ", 2020 оны 246 дугаар тогтоол "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам", Газрын дүрэм, Нэгжийн дүрэм, албан тушаалын тодорхойлолт, бусад холбогдох эрх зүйн актуудтай танилцсан баталгааны маягт дээр гарын үсгээр баталгаажуулж авсан. | |
| | | 2.2.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах. | -Өөрсдийн нөөц боломжоонд тулгуурлан зохион байгуулсан байх;<br><br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Ebarilga.ub.gov.mn геопортол, гар утасны аппликэйшн шинээр ашиглалтад оруулан авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулж 9 төрлийн 37 үйлчилгээг цахимаар хүн, хуулийн этгээдээс хүлээн авч байна. Хүн, хуулийн этгээд өөрийн илгээсэн хүсэлтийн явц, шийдвэрлэлтийг хянах боломжгой.<br>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн "Журам, жагсаалт, загвар батлах тухай" 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний жагсаалт" 14 үйлчилгээг (дугаар 223-236) И-Монгол академи ТӨҮГ-ын Систем хөгжүүлэлтийн хэлтэс, eBarilga хот байгуулалтын цахим системийн хөгжүүлэгч Смарт дата ХХК-тай хамтран эхний 13 үйлчилгээний холболтын ажлын бүрэн дуусгахаар цахим хурал зохион байгуулж системийн хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлэн тестийн серверт туршилтын ажил хийгдэж байна. 2025 онд багтаж бүрэн ажиллагаанд орно.<br><br>1.Нийтийн эдэлбэрийн газрыг хүн, хуулийн этгээдийн хөрөнгөөр тохижуулах, ашиглах, хамгаалах хүсэлтийг шийдвэрлэх<br>2.Нийтийн эдэлбэр газарт авто зогсоол төлөвлөх, байгуулах хүсэлтийг шийдвэрлэх<br>3.Барилга, байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгаврын схем зургийн эргэлтийн цэгийн солбицол өөрчлүүлэх хүсэлт<br>4.Гадна зар сурталчилгааны байгууламжийн загвар зураг батлах<br>5.Барилгын ажил эхлүүлэх-Шинээр олгох, сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах<br>6.Барилгын ажил эхлүүлэх-Буулгах зөвшөөрөл<br>7.Барилгын ажил эхлүүлэх-Цахилгааны ажлын зөвшөөрөл<br>8.Барилгын ажил эхлүүлэх-Инженерийн шугам сүлжээний<br>9.Инженерийн бэлтгэл арга хэмжээ үерийн далан суваг, хөрсний усны трасс зөвшилцөх, зөвшөөрөлцөх үйлчилгээ<br>10.Мэдээлэл холбооны шугам сүлжээний трасс зөвшилцөх, зөвшөөрөлцөх үйлчилгээ | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | 11.Дулаан хангамжийн шугам сүлжээний трасс зөвшилцөх, зөвшөөрөлцөх үйлчилгээ<br>12.Цахилгаан хангамжийн шугам сүлжээний трасс зөвшилцөх, зөвшөөрөлцөх үйлчилгээ<br>13.Усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний трасс зөвшилцөх, зөвшөөрөлцөх үйлчилгээ<br>Тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br><br>Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссарын 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр баталсан “Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар”-т тандалтаар ажиллах төлөвлөгөөт ажлын хүрээнд барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл, барилга, авто зам, гадна тохижилтын загвар зураг болон нөхөн батлуулсан, төрийн тусгай хамгаалттын газарт барилга байгууламж барих зөвшөөрөл хүссэн судалгааг заасан хугацаанд гарган өгч, холбогдох тайлбар мэдээллийг хүргүүлж ажиллав. bayartsetseg@iaac.mn | |
| 3 | Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | 3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх; | -Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх;<br>-Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх;<br>-Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах;<br>-Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх; | Хот байгуулалтын дотоод үйл ажиллагаатай холбоотой 4 гэрээнд дараах 3 заалтыг тусган ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдлийг хувийн хэрэгт хавсаргасан.<br>1. “энэхүү гэрээтэй холбоотой ажил гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй” гэж.<br>2. “гэрээний үүрэг биелээгүйгээс учирсан хохирлыг буруутай тал нь барагдуулна” гэж тухайлсан гэрээний хариуцлага бүлэгт,<br>3. “захиалагч тал нь гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тохиолдолд гүйцэтгэгч талын хийсэн ажлын төлбөрийг бүрэн төлөх үүрэгтэй бөгөөд ажлын гүйцэтгэл 50 хувиас дээш гарсан тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхгүй болно” гэж гэрээний “Захиалагч тал” бүлэгт. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | -Тайланд нотломжийг хавсаргасан байх. | | |
| 4 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м) | -Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх ; | 2025 онд шинээр байгуулсан 4 гэрээнд Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх мэдэгдэх хуудсыг гаргуулан ажилласан. Хот байгуулалтын гэрээ, түүний биелэлтийн явцын талаарх мэдээллийг газрын дотоод сүлжээнд тухай бүр байршуулж ажиллав.<br><br>Он дамжин ирсэн хот байгуулалтын үйл ажиллагаатай холбоотой зөвлөх үйлчилгээний 13, байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой иргэн, аж ахуй нэгжтэй байгуулсан 20 гэрээний үүргийн биелэлтэд тавин ажиллаж байна.<br>Z:\11.KHUULIIN KHELTES\4.DOTOOD AJIL\GEREE<br>Z:\11.KHUULIIN KHELTES\4.DOTOOD AJIL\GEREE\HUT BAILGUULLALTIIN GEREE\2025 ON | 100 |
| | | 4.2.Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх; | -2-оос доошгүй зохион байгуулсан байх;<br>-Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх | Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ойн хүрээнд “Бүсчилсэн хөгжил-төрийн албаны манлайлал” зөвлөгөөнд Газрын дарга, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, Хуулийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч, Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн, байгууллагын Ёс зүйн дэд хорооны Нарийн бичгийн дарга, гишүүдийн төлөөлөл зэрэг 7 албан тушаалтан 2025 оны 05 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд оролцож, “Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэглээ” хэлэлцүүлэг, “Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ” салбар хэлэлцүүлэгт оролцож, санал, хүсэлтээ танхимаар болон цаасаар гарган зөвлөмж авч оролцсон.<br><br>Удирдлагын академиас зохион байгуулсан 2025 оны 04 дүгээр сарын 28-нд Ёс зүйн дэд хорооны Нарийн бичгийн дарга “Авлигаас ангид төрийн алба” анхан шатны цахим сургалтад хамрагдаж сертификат авсан.<br><br>Авлигатай тэмцэх газраас 2025 оны 12 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд зохион байгуулсан Авлигын эсрэг хуульд заасан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | сургалт, сурталчилгаа явуулах “Сургагч багш” бэлтгэх анхан шатны сургалтад Ёс зүйн дэд хорооны гишүүн хамрагдаж сертификат авсан.<br><br>2023 оноос хойш 3 дахь жилдээ Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй "Явган замын хавтан, авто замын хашлагийн стандартыг мөрдүүлэх асуудлаар" нийслэлийн 9 дүүрэгтэй хийх уулзалтад тус газраас ”Явган замын хавтан, авто замын хашлагатай холбоотой мөрдөгдөж буй стандартыг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, зөрчлүүд” сэдвийн хүрээнд танилцуулга хийж оролцов. | |
| 5 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | 5.1. Удирдлагын зүгээс 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдад танилцуулах; | -Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Газрын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн жилийн ажлын тайланг нийт албан хаагчдад танилцуулж, 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг танилцуулан, холбогдох нэгж, албан тушаалтан (дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогч), Залуучуудын хөгжлийн зөвлөл, Ёс зүйн дэд хорооны саналыг тусган эцэслэж Газрын даргаар 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр батлуулж ажиллав.<br>Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт, тайлан мэдээг 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/692 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, тайлагнав. | 100 |
| | | 5.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал; | -Санал тусгасан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2025 оны IV дүгээр хурлаар 2024 оны үйл ажиллагааны биелэлтийг хэлэлцэж, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр 17 заалт бүхий Хот байгуулалт, хотын стандартын газрын ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж хагас жилээр тайлагнан ажиллав.<br>Газрын ёс зүйн дүрмийг Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-г үндэслэн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулсан.<br>Байгууллагын www.uds.ub.gov.mn цахим хуудасны Мэдээ, мэдээлэл буланд Хот байгуулалт, хотын стандартын газрын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг, Ил тод байдал цэсийн Ёс зүйн буланд Хот байгуулалт, хотын стандартын газрын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг байршуулж, ил тод байдлыг ханган ажилласан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | 5.3.Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулах | -Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх;<br>-khutulbur.iaac.mn (Авлигын эсрэг Үндэсний хөтөлбөр) цахим санд нэмж оруулсан байх,<br>-Тайлагнасан байх. | Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шил” ажиллагааны хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор 2023 оноос Нийслэлийн Ерөнхий архитекторын дэргэдэх хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх зөвлөлийн хурлыг иргэд, олон нийтэд нээлттэйгээр цахим хаягаар шууд дамжуулан ажиллаж байгаа бөгөөд 2025 оны эхний хагас жилд 62 удаагийн хурлыг цахимаар хийж, Мэргэжлийн зөвлөлийн хурлын жагсаалт, хурлын саналыг нээлттэй байршуулан ажиллав. https://uds.ub.gov.mn/commission<br>Иргэн, хуулийн этгээдээс газарт утсаар хандан мэдээлэл, зөвлөгөө авах, мэргэжилтэнтэй холбогдох хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх хүрээнд “Операторын үйлчилгээ”-г нэвтрүүлэн дуудлага бүрд хариулан түргэн шуурхай үйлчилгээг харилцаа холбооны Коллпро ХХК-тай хамтран “Та залга бид хариулъя” уриатайгаар 2024 оноос нэвтрүүлэн ажиллаж байна. Ингэснээр нэг ч дуудлага алдахгүй давуу талтай.<br><br>2025 оны 01 дугаар сарын 02-ны өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл нийт 18703 дуудлага иргэн аж ахуйн нэгжээс хүлээн авч зөвлөгөө мэдээллээр хангаж холбогдох албан хаагч нартай холбон өгч ажилласан.<br><br>Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ойн хүрээнд “Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл” аяны хүрээнд “Бид иргэдээ сонсож шийднэ” гэсэн уриатайгаар иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлтийг нь сонсож, газрын үйл ажиллагааг сурталчлах, газраас үзүүлж буй үйлчилгээний талаар иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээлэл өгөх нээлттэй өдрийг Яармаг дахь Төрийн үйлчилгээний нэг цэгт 2025 оны 04 дүгээр сарын 21-25-ны өдрүүдэд зохион байгуулж ажилласан. | 100 |
| | | 5.3.1 Байгууллагын удирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэл, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулах, тушаалын хэрэгжилтэд хяналт | - Ажлын хэсэг байгуулсан, хэн нэгэн албан тушаалтанд даалгасан тушаалын хэрэгжилтэд үр дүнг тооцсон байх, | Газрын үндсэн үйл ажиллагаатай холбоотой гарсан А/65 тушаал, хүний нөөцийн чиглэлээр гарсан Б/182 тушаалын төслийн хууль зүйн үндэслэлтэй эсэхэд Хуулийн хэлтэс хяналт тавьж ажиллав. Газрын даргын тушаалаар баталсан байнгын үйл ажиллагаатай ажилладаг 5 ажлын хэсгийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, жилийн ажлын төлөвлөгөөг Газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Сахилга хариуцлага, төрийн үйлчилгээг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” А/62 | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | тавих (Жишээ нь: тушаал шийдвэр гаргахдаа үндэслэх хэсэгт хамааралгүй хууль, тогтоол, захирамжийг үндэслэн тушаал гардаг асуудлыг арилгахад чиглэсэн) | | дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж албан хаагчдын сахилга хариуцлага, дэг журмыг чангатгаж, хариуцлагатай, ил тод, мэргэшсэн, төрийн үйлчилгээг хүргэх зорилгоор ажил сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр Газрын даргын 2025 оны “Ажил сайжруулах, сахилга хариуцлагыг өндөржүүлэх тухай” А/08 дугаартай тушаал гаргаж нийт албан хаагчдад танилцуулж гарын үсгээр баталгаажуулан ажиллав.<br><br>Захирамжийн хэрэгжилтийг сар бүрийн 25-ны өдөр тайлагнаж байх гэсэн үүрэг даалгаврын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газарт албан бичгээр хүргүүлэн ажиллав. Үүнд:<br>- 03 дугаар сарын хэрэгжилтийг 2025 оны 01/311 дугаартай албан бичгээр,<br>- 04 дүгээр сарын хэрэгжилтийг 2025 оны 01/430 дугаартай албан бичгээр,<br>- 06 дугаар сарын хэрэгжилтийг 2025 оны 01/767 дугаартай албан бичгээр,<br>- 07 дугаар сарын хэрэгжилтийг 2025 оны 02/179 дугаартай албан бичгээр,<br>- 08 дугаар сарын хэрэгжилтийг 2025 оны 01/967 дугаартай албан бичгээр,<br>- 09 дүгээр сарын хэрэгжилтийг 2025 оны 01/1123 дугаартай албан бичгээр,<br>- 10 дугаар сарын хэрэгжилтийг 2025 оны 01/1123 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлж, хэрэгжилтийг газрын дотоод сүлжээ (Z:\0.KHOT BAIGUULALT, KHOTIIN STANDARTIIN GAZAR\4. BIYLELT\6. 2025\4. NIISLELIIN BARIMT BICHIG\5. NZD -IIN ZAHIRAMJ\НЗД 2025-А62 хэрэгжилт) | |
| | | 5.3.2 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргаж байгаа өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хугацаа хэтрүүлэхгүй байх, бодитой шийдвэрлэж хугацаанд нь зохих хариу өгөх ажлыг сайжруулах ажил зохион байгуулах. (Албан хаагчдын ёс | -Үр дүнг тооцсон байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх | Байгууллагын хэмжээнд нийт 1252 өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэснээс албан хаагчтай холбоотой 8 гомдол хүлээн авснаас:<br>• Үйлчилгээний ажилтан – Операторын үйл ажиллагаатай холбоотой 3 гомдол (утсаа аваагүй 2, зан харилцаа -1) үүссэн нөхцөл байдлын талаар уучлал гүйж, тайлбар өгч ажиллав.<br>• Албан хаагчийн нэр дурдаж ирсэн 5 гомдолд дотоод хяналт хийгдэж, 4 өргөдөлд албан хаагчийн буруутай үйлдэл тогтоогдоогүй. 1 албан хаагчийн буруутай үйлдэл нь газрын Хөдөлмөрийн дотоод журмын 12 дугаар зүйлийн 12.2.4 дэх заалтыг зөрчиж сахилгын хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байсан тул газрын “Ёс зүйн дэд | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | зүйн зөрчил, дутагдал хамаарах) | | хороо"-ны хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байгаа болно.<br><br>Байгууллагын хэмжээнд өргөдөл, гомдлын хандалт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 863 буюу 41 хувиар буурсан үзүүлэлттэй байна. (2024 он – 2115 өргөдөл, гомдол)<br><br>2025 оны эхний хагас жилд өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн явцад эхний хагас жилд 4, сүүлийн хагас жилд 2 зөрчил гарсан.<br><br>2025 онд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцад гарсан 6 зөрчил 2024 онтой харьцуулахад (48 зөрчил) 88 хувиар буурсан.<br><br>Зөрчил гаргасан 6 албан хаагчдад өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцад зөрчил гаргахгүй байх, дээрх зөрчлийг давтан гаргасан тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохыг мэдэгдэж, Газрын даргаар баталгаажуулсан "Мэдэгдэх хуудас" өгч, ажлын үр дүнгийн үнэлгээний үзүүлэлтээс зөрчлийн тоогоор 5 оноо хасаж тооцов.<br><br>Байгууллагын алба хаагчдад ёс зүйн зөрчлөөс ангид байх, цаашид сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх тал дээр цаг тухай бүрд зөвлөмж өгч ажилласан ба алба, хэлтсийн ахлах мэргэжилтнүүдэд цаг үеийн байдлаар мэдээлэл өгсөн. | |
| | | 5.3.3 Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журам нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, Засгийн газрын тогтоолоор хүчин төгөлдөр бус болсон эсэхэд | -Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох дүрэм, журмыг хяналтад авч, кодификаци хийсэн байх | Байгууллагын цахим хуудас дахь "Хууль, дүрэм журам" булан дахь хуулиуд, Улсын их хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, газрын даргын тушаалаар батлагдсан дүрэм журмын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эсэхэд хяналт тавьж тогтмол шинэчлэлтийг хийн ажиллаж байна. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | хяналт шинжилгээ, үнэлгээ хийх. | | | |
| | | 5.3.4 Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга, батыг сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулах. (Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах, Нийслэл, Үндэсний аудитын газраас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус аудитын шалгалтаар жил бүр илэрдэг санхүүгийн зөрчил, дутагдлыг цаашид гаргахгүй байхад чиглэсэн үр дүнтэй ажил зохион байгуулах) | -Төсөв, санхүүгийн зөрчилгүй ажиллах<br>-Сүүлийн 2 жилийн хугацаанд илэрсэн зөрчил дутагдлыг давтан гаргаагүй байх | Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн Захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлт гарч, төсвийн гүйцэтгэлийг батлуулсантай холбогдуулан Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 368 дугаартай албан бичгээр ирүүлсэн аудитын дүгнэлтээр “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан.<br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 03/3808 дугаартай албан бичгээр 2024 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлж “Өөрчлөлтгүй” дүгнэлт авч үр бүтээлтэй ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтанд батлагдсан төсвийн хүрээнд урамшуулал олгох талаар чиглэл ирүүлсэн.<br><br>Газар нь сүүлийн 2 жил дараалал санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан байна.<br>Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр 2 албан шаардлага хүлээн авч, албан шаардлагын хэрэгжилтийг ханган ажилласан. 2024 оны санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтээр 2 зөвлөмж авч хэрэгжилтийг тус тус ханган ажилласан байна.<br><br>Батлагдсан төсвийг үр ашигтай төлөвлөн зарцуулж батлагдсан төсвийн хуваарийн дагуу гүйцэтгэлийг хийж ажиллав. | 100 |

ТАНИЛЦСАН: ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ДАРГА Г.БАЯРСАЙХАН

ХЯНАСАН: ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.ДАШЦЭЦЭГ

ТАЙЛАН ГАРГАСАН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Т.БУЯНЖАРГАЛ

Албан хаагчдад зориулсан ажлын байран дахь сургалтын хөтөлбөрийг 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Газрын даргаар батлуулав. Шинээр томилогдсон албан хаагчдад хөтөлбөрийн дагуу 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр 8 албан хаагчдад сургалт зохион байгуулав.



Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн Комиссар, мэргэжилтэн С.Баярцэцэг “Төрийн албан хаагчдыг авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх” сэдэвт сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр хийж, сургалтад байгууллагын албан хаагчдын 90% хамрагдсан.



Байгууллагын дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөлөөс “АВЛИГАГҮЙ ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ – АВЛИГА ГАРЦ БИШ” зурагт хуудас гарган Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын ERP нэгдсэн системээр болон байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудас зэрэгт байршуулан залуучуудын санал санаачилгыг түгээж, нийт албан хаагчдад уриалан ажиллав. https://uds.ub.gov.mn/avilaga.php



**Хот байгуулалт, хотын стандартын газар**
12-р сарын 9 өдрийн 08:38 цаг ·

Ил тод байдал бол бидний нийтлэг үнэт зүйл.
12 сарын 9 — Авлигын эсрэг олон улсын өдөр.




Та, Б. Мягмардорж, Urnaa Dash ба өөр 13 хүн

2 удаа хуваалцсан

Таалагдлаа   Сэтгэгдэл   Хуваалцах

Байгууллагын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан арга хэмжээний хүрээнд байгууллагын нийт албан хаагчдын дунд Үндсэн хуулийн түүхэн ач холбогдол, Үндсэн хуульт төрийн байгуулал, хууль ёсоо эрхэмлэн дээдлэх үзэл санааг таниулах, үндэсний үнэт зүйлдээ хандах мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах, ёс зүйн манлайллыг төлөвшүүлж, итгэл төрүүлэх төрийн үйлчилгээг бий болгох соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулахаар Газрын даргын 2025 оны 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/63 дугаар тушаалаар батлуулж, 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан. Сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 1,200,000 төгрөг зарцуулав. https://www.facebook.com/uda.ub.gov

Систем хариуцсан ажилтан UB ERP ADMIN
*. UB ERP ADMIN .*

1 өдрийн өмнө

Хот байгуулалт, хотын стандартын газар
Монгол Улсын Анхдугаар Үндсэн хуулийг
баталж, Бүгд Найрамдах Улсыг тунхагласны
101 жилийн ой, байгууллагын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө,
Байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөнд
тусгагдсан арга хэмжээний хүрээнд
"Quiz-101" танин мэдэхүйн тэмцээнийг байгууллагын нийт албан хаагчдын дунд 2025
оны 12 дугаар сарын 12-ны өдөр амжилттай зохион байгууллаа.
Тэмцээний зорилго нь төрийн албан
хаагчдын Үндсэн хууль, авлигын эсрэг хууль
тогтоомж, ёс зүйд суурилсан мэдлэгийг
нэмэгдүүлэх, оролцоог дэмжих, соён
гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэхэд чиглэв.



Нийт

Дэмжих 17

Сэтгэгдэл

**Хот байгуулалт, хотын стандартын газар Нийслэлийн Засаг даргын Тамгын газар**-тай хамт байна.

6d ·

Монгол Улсын Анхдугаар Үндсэн хуулийг
батлаж, Бүгд Найрамдах Улсыг тунхагласны
101 жилийн ой, байгууллагын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө,
Байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөнд
тусгагдсан арга хэмжээний хүрээнд
"Quiz-101" танин мэдэхүйн тэмцээнийг байгууллагын нийт албан хаагчдын дунд 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр амжилттай зохион байгууллаа.
Тэмцээний зорилго нь төрийн албан
хаагчдын Үндсэн хууль, авлигын эсрэг хууль
тогтоомж, ёс зүйд суурилсан мэдлэгийг
нэмэгдүүлэх, оролцоог дэмжих, соён
гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэхэд чиглэв.



Удирдлагын академиас зохион байгуулсан 2025 оны 04 дүгээр сарын 28-нд Ёс зүйн дэд хорооны Нарийн бичгийн дарга “Авлигаас ангид төрийн алба” анхан шатны цахим сургалтад хамрагдаж сертификат авсан.

УДИРДЛАГЫН АКАДЕМИ

# ҮНЭМЛЭХ

№ 719876

**Даш-Адъяа овогтой Уранбайгаль**

**Төрийн албан хаагчдад зориулсан “Авлигаас ангид төрийн алба” анхан шат**

ЦАХИМ СУРГАЛТАД АМЖИЛТТАЙ ХАМРАГДСАН ТУЛ ЭНЭХҮҮ ҮНЭМЛЭХИЙГ ОЛГОВ.

**Д.СҮРЭНЧИМЭГ**
*Доктор, дэд профессор*
Удирдлагын академийн захирал

**Д.БАЙГАЛ**
*Доктор, профессор*
Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн захирал

2025.4

Авлигатай тэмцэх газраас 2025 оны 12 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд зохион байгуулсан Авлигын эсрэг хуульд заасан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах “Сургагч багш” бэлтгэх анхан шатны сургалтад Ёс зүйн дэд хорооны гишүүн хамрагдаж сертификат авсан.



ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД

НИЙСЛЭЛИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛ

ГЭРЧИЛГЭЭ

№...

..........Б. Бямбажаргал.......... нь

Авлигын эсрэг хуульд заасан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах “СУРГАГЧ БАГШ” бэлтгэх анхан шатны сургалтыг амжилттай дүүргэсэн тул ГЭРЧИЛГЭЭ олгов.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА, ЭРХЭЛСЭН КОМИССАР З.БААСАННЯМ

УЛААНБААТАР ХОТ
2025.12.02

Сургагч багш бэлтгэх анхан шатны сургалтын хүрээнд дараах сэдвийн хичээлд бүрэн хамрагдсан болно.

Үүнд:

- Илтгэх ур чадвар
- Сургалт хийх арга зүй
- Сургалтад мэтгэлцээний арга хэлбэр ашиглах нь
- Сургалтын слайд хэрхэн сонирхолтой боловсруулах вэ?
- Шударга ёс ба үнэт зүйл
- Монгол Улс дахь авлигын нөхцөл байдал
- Судалгаа, шинжилгээний үр дүнг сургалт, мэдээлэл, үйл ажиллагаанд ашиглах нь
- Авлигын ойлголт, шалтгаан, хор хөнөөл
- Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь
- Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой анхаарах зарим асуудал
- Авлигатай тэмцэж буй олон улсын туршлага
- Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах
- Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа
- Авлигын гэмт хэрэг: Ойлголт, зохицуулалт

Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбараар байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг сурталчлан холбогдох мэдээллийг байршуулав.

2025 оны эхний хагас жилд өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн явцад эхний хагас жилд 4, сүүлийн хагас жилд 2 зөрчил гарсан.

2025 онд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцад гарсан 6 зөрчил 2024 онтой харьцуулахад (48 зөрчил) 88 хувиар буурсан.

Зөрчил гаргасан 6 албан хаагчдад өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцад зөрчил гаргахгүй байх, дээрх зөрчлийг давтан гаргасан тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохыг мэдэгдэж, Газрын даргаар баталгаажуулсан "Мэдэгдэх хуудас" өгч, ажлын үр дүнгийн үнэлгээний үзүүлэлтээс зөрчлийн тоогоор 5 оноо хасаж тооцов.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР**

# МЭДЭГДЭХ ХУУДАС

2025 оны 10 дугаар сарын 20 №21 Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар батлагдсан "Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.3-т "Энэ журмын 4.10-т заасны дагуу өргөдөл, гомдолтой танилцсан албан хаагч уг асуудлыг өөрөө биечлэн хянаж шийдвэрлэхээргүй бол түүнийг хэрхэн судалж шийдвэрлэх талаар удирдлагын тэмдэглэл /цохолт/ бичиж, харьяалах доод шатны байгууллага, албан хаагчид хянан шийдвэрлүүлэхээр ажлын 8 цагт багтаан шилжүүлнэ."

Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Сахилга хариуцлага, төрийн үйлчилгээг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/62 дугаар захирамжийн 1 дэх заалтын 1.1.2 дахь хэсэг, Хот байгуулалт, хотын стандартын газрын 2025 оны "Ажил сайжруулах, сахилга хариуцлагыг өндөржүүлэх тухай" А/28 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2025 оны 01 дүгээр хуралдааны тэмдэглэлийн 10 дугаарт "Иргэдээс 2024 онд гаргасан өргөдөл, гомдол хариутай албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй байгууллага, албан тушаалтанд анхааруулга өгч, 2025 онд дээрх зөрчлийг гаргасан албан тушаалтныг ажлаас чөлөөлөх хариуцлага тооцож ажиллахыг нийт байгууллагын удирдлагуудад, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т үүрэг болгосон.

Захиргаа, удирдлагын хэлтсийн Архивын эхлэгч **Г.ЭНХЦЭЦЭГ** нь 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр G250828087 дугаартай өргөдлийг **"Өдөрт нь багтаан хүлээн аваагүй" зөрчил** гаргасан байна.

Иймд Захиргаа, удирдлагын хэлтсийн Архивын эхлэгч **Г.ЭНХЦЭЦЭГ** ТА өргөдөл гомдол, албан бичгийн шийдвэрлэлтийн явцад зөрчил гаргахгүй байх, зөрчлийг давтан гаргасан тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохыг энэхүү хуудсаар мэдэгдэж байна.

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.БАЯРСАЙХАН

МЭДЭГДЭЛ ХҮЛЭЭН АВСАН:

| О. Эн | О.Энхцэцэг | 2025.11.04 |
|---|---|---|
| Гарын үсэг | Овог, нэр | Огноо |

Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбараар байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг сурталчлан холбогдох мэдээллийг байршуулав.




НИЙСЛЭЛИЙН ЗАС
ХОТ БАЙГУУЛАЛТ,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ИЛ ТОД БАЙДАЛ
ТАНИЛЦУУЛГА
ХҮНИЙ НӨӨЦ
ТӨСӨВ, САНХҮҮ
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ
МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ
www.uda.ub.gov.mn
Өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн Утас: 72707700
Үйлчилгээний талаар зөвлөгөө авах, мэдээллийн лавлах 72707700
Хот байгуулалт, хотын стандартын газар


КҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АНДАРТЫН ГАЗАР
ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ
ИЛ ТОД БАЙДАЛ
eBARILGA
110
ЗӨВЛӨМЖ
СУРТАЛЧИЛГАА
мэдээлэл
ЛАВЛАХ УТАС
72707700
110
САНАЛ ХҮСЭЛТ
ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ
110
www.iaac.mn

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

БАЯРСАЙХАН

2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр

АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН АЖЛЫН БАЙРАН ДАХЬ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр

| № | СУРГАЛТЫН СЭДЭВ | ХАМРАГДАХ АЛБАН ХААГЧ | ХУГАЦАА ДАВТАМЖ | ХАРИУЦАХ АЛБАН ХААГЧ |
|---|---|---|---|---|
| 1 | “Төрийн албаны тухай хууль”, “Иргэдээс Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын танилцуулга | Шинээр томилогдсон албан хаагч | Тухай бүр (30 мин) | Хуулийн хэлтэс Ж.Халиун |
| 2 | Албан хэрэг хөтлөлт (журам, ERP, eDoc, өргөдөл гомдлын систем), анхаарах асуудлууд | Шинээр томилогдсон албан хаагчид болон нийт албан хаагчид | Тухай бүр 60 мин | Захиргаа, удирдлагын хэлтэс Л.Адьяасүрэн Ч.Хишигжаргал |
| 3 | eBarilga системийн танилцуулга | Шинээр томилогдсон албан хаагч | Тухай бүр 20 мин | Хотын орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс Д.Уранбайгаль, Т.Жамц |
| 4 | Хот байгуулалт, хотын стандартын газрын бүтэц, орон тоо, чиг үүргийн танилцуулга, “Газрын Хөдөлмөрийн дотоод журам”, дотоод сүлжээ, түүний ашиглалт | Шинээр томилогдсон албан хаагч | Тухай бүр 30 мин | Захиргаа, удирдлагын хэлтэс Т.Буянжаргал |
| 5 | “Хувийн ашиг сонирхлын болон Хөрөнгө орлогын мэдүүлэг, анхаарах зарим асуудлууд”, “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар” | Шинээр томилогдсон албан хаагч | Тухай бүр 1 цаг | Захиргаа, удирдлагын хэлтэс Т.Буянжаргал |
| 6 | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, бусад дүрэм журам, ёс зүйн дүрэм, ёс зүйн дэд хорооны ажиллах журам | Шинээр томилогдсон албан хаагчид болон нийт албан хаагчид | Тухай бүр 1 цаг | Ёс зүйн дэд хороо |
| 7 | Бусад | | | |

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

**ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 12 сарын 01 өдөр Дугаар А/63 Улаанбаатар хот

Сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, "Газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ёс зүйн хорооноос 11 дүгээр сарыг "Хүндэлье – Энэрье" ёс зүйн нөлөөллийн сар болгон зарласантай холбогдуулан байгууллагын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан арга хэмжээний хүрээнд байгууллагын нийт албан хаагчдын дунд Үндсэн хуулийн түүхэн ач холбогдол, Үндсэн хуульт төрийн байгуулал, хууль ёсоо эрхэмлэн дээдлэх үзэл санааг таниулах, үндэсний үнэт зүйлдээ хандах мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах, ёс зүйн манлайллыг төлөвшүүлж, итгэл төрүүлэх төрийн үйлчилгээг бий болгох соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсугай.

2.Сургалт, нөлөөллийн арга хэмжээний нийт зардал 1,200,000 (нэг сая хоёр зуу) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (Н.Лхам)-д зөвшөөрсүгэй.

3.Сургалт, нөлөөллийн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Ёс зүйн дэд хороо (Н.Дарханбаяр), Залуучуудын хөгжлийн зөвлөл (М.Амарзаяа), Захиргаа, удирдлагын хэлтэс (Д.Дашцэцэг)-т нарт тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.БАЯРСАЙХАН

W:\2025\1 Tushaal_A-2025

1725010545